



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2017 оны 11 дугаар сарын 21

№ 05/88 УАГ-НАГ/2017/03-НА

Мандалговь хот

Г

Г

**Зөрчил арилгуулах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2, 19 дүгээр зүйлийн 19.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д нийцлийн аудит хийх явцад Луус сумын сургууль төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээнүүдийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хоосон хадгалж, 251,725,700.00 /Хоёр зуун тавин нэгэн сая долоон зуун хорин таван мянга долоон зуун/ төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар бүлгийн 6.1.2. дахь /хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор;/ заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол улсын Ерөнхий аудиторов 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.7-дахь /Хууль тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал;/ заалтуудыг үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд үнэн зөвөөр мэдээлэх,
2. Шилэн дансны тухай хууль, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга нийтлэг стандартыг тогтоох журмыг уншиж судлан хэрэгжилтэд хяналт тавих, хариуцсан ажилтны ажлын хариуцлагыг сайжруулах,
3. Шилэн дансны мэдээллийг хуулинд заасан цаг хугацаанд үнэн зөвөөр бүрэн мэдээлж, ажил гүйлгээ гараагүй тохиолдолд “байхгүй” гэдгээр цахим хуудсанд тэмдэглэл хийж байх.


Албан шаардлагын биелэлтийг 2017 оны 11 дүгээр сарын 20-ны дотор аймгийн Төрийн аудитын газарт ирүүлэхийг Луус сумын есөн жилийн сургуулийн захирал /Н.Долгоржав/, нягтлан бодогч /Н.Нармандах/ нарт даалгав.

## АЛБАН ШААРДЛАГЫГ



**ЗӨВШӨӨРСӨН:**

ЛУУС СУМЫН ЕСӨН ЖИЛИЙН СУРГУУЛИЙН

|                                                                                                    |             |
|----------------------------------------------------------------------------------------------------|-------------|
| ЗАХИРАЛ         | Н.ДОЛГОРЖАВ |
| НЯГТЛАН БОДОГЧ  | Н.НАРМАНДАХ |

---

<sup>1</sup> Албан шаардлагыг биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т /Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтанг ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ/